

**Монголбанкны авлигаас урьдчилан сэргийлэх 2016 оны ажлын  
төлөвлөгөөний 3 дахь заалтын биелэлтийг  
(2016 оны II улирлын байдлаар)**

Хяналт шалгалтын газраас 2016 оны 2 дугаар улиралд хяналт шалгалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Тайлант улиралд 3 банкинд газар дээрх иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтаар холбогдох журмын дагуу зээлийн ангиллыг хийж, зээлийн эрсдэлийн санг байгуулдаггүй, хуримтлуулж тооцсон хүүг тэнцлийн гадуур гарган бүртгэдэггүй, зээлийн мэдээллийн санд мэдээллээ бүрэн гүйцэд нийлүүлээгүй, Банкны тухай хуулийн 32.1 болон 33.3 дугаар зүйлийг зөрчсөн зэрэг дутагдлууд илэрлээ. Дээрх банкуудад хийсэн шалгалтын дүнг Хяналт шалгалтын зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулан ажилласан бөгөөд өмнөх шалгалтаар өгсөн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 25-ны А-207 тоот тушаалаар “Банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ын дагуу 12 банкны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг хийж дараагийн газар дээрх шалгалтын хугацаа, чиглэл, хамрах хүрээг тусгасан зайнаас хяналтын дүгнэлт гаргаж ажилласан.
- Тайлант хугацаанд нийт 7 эрүү, иргэний хэрэгт нийт 14 хянан шалгагч шинжээчээр ажиллаж, шинжээчийн дүгнэлт гаргаж холбогдох хууль хяналтын байгууллагад хүргүүлсэн байна.
- Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчилсэн “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ын дагуу банкны сарын тайланг хүлээн авч, нэг эх сурвалжид төвлөрүүлэх, нээлттэй удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Банкны тайланг хүлээн авч, системийн нэгтгэл хийх Фина системийг 2016 оны 1 дүгээр сараас хойш албан ёсоор тасралтгүй ашиглаж байгаа бөгөөд олон төрлийг тайлан, мэдээ гаргах арга хэмжээг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.
- Санхүүгийн зохицуулах хороотой хамтран зээлийн мэдээллийн санд хандах, мэдээлэл солилцох эрхийг шаардлага хангасан 22 ББСБ, 1

ХЗХ-нд зээлийн мэдээлэл солилцох эрх олгосон. Өнөөдрийн байдлаар 302 ББСБ, 79 ХЗХ зээлийн мэдээллийн сантай холбогдоод байна.

- Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А-58 дугаар тушаал, Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар маягтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-200 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 дүгээр тушаалаар батлагдсан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу банкуудаас 2016 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ирүүлсэн зохистой засаглалын хэрэгжилтийн тайланг хянаж үнэлгээ дүгнэлт өгөн, холбогдох хариуг 2016 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор банкуудад хүргүүлсэн болно.
- Банкуудын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтын хүрээнд банкуудын санхүү, төлбөрийн чадварын талаарх ерөнхий дүгнэлт, мэдээллийг боловсруулж, банкуудаас ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг, материалыг хууль, журам, зааврын дагуу шалгаж удирдлагад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулах, банкинд хийх хяналт шалгалтыг хугацаанд нь чанартай, тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч байна.
- Зайнаас хяналт тавих хэлтсийн зүгээс банкны системийн чанаргүй зээл нэмэгдэж байгаатай холбогдуулан Монголбанкны 2016 оны дотоод ажлын төлөвлөгөөний дагуу 6 банкны 40 том зээлдэгчийн зээлийг хянан шалгаж, энэ талаар улирал бүрийн банкинд зайнаас тавьсан хяналтын дүгнэлтэнд тусгах, холбогдох танилцуулга боловсруулан Хяналт шалгалтын зөвлөлийн гишүүд болон Монголбанкны удирдлагуудад танилцуулах замаар тухай бүр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**